

ИЛГЭЭЛТИЙН ХАРААТАЙ БҮЛГИЙГ БАЙГУУЛАХ



АЛХМУУД



1 СОНГОХ



Хаана? Таны эргэн тойронд
Есүсийг мэдэх хэрэгтэй бүлэг.




Хэн? Тухайн бүлэгтэй таныг холбож
өгөх амар тайвны хүн



Хэнтэй? Өсөж
олшрох Тимот.

2 ҮЗҮҮЛЭХ

10 ба түүнээс олон хүнтэй
бүлэгт ЕСҮС киног үзүүлж,
Есүсийн тухай илүү ихийг
таньж мэдэхэд уриана.




3 ЭХЛЭХ

Илгээлтийн хараатай бүлгийг дагалдуулах
сургалтын 3/3 гурваны гурав үйлдлийн
дагуу эхэлнэ.

4

ОЛШРОХ

Тимотыг илгээлтийн
хараатай бүлгийг
эхлүүлэхээр илгэнэ.



ТҮЛХҮҮР ҮГС

АМАР ТАЙВНЫ ХҮН

Хүндлэгдсэн, сүнсний зүйлсийг сонирхдог, найз
нөхөд болон гэр бүлээ **ЕСҮСИЙГ**
уриалах хүн. (Лук 10:6)

ТИМОТ

Сурах хүсэлтэй, итгэмжтэй, Илгээлтийн Хараатай
Бүлгийг олшруулах чадамжтай итгэгч. (Тимот 2:2)

ИЛГЭЭЛТИЙН ХАРААТАЙ БҮЛЭГ

Өнөр гэр бүлийн хэмжээтэй, шинэ сүнслэг бүлгийг
эхлүүлэхийн тулд ажиллаж, өсөн олширдог сүнслэг
бүлэг.

3/3 ИЛГЭЭЛТИЙН ХАРААТАЙ БҮЛГИЙН ЦУГЛАРАЛТ ДЭЭРХ ДАГАЛДУУЛАХ БҮТЭЦ



Эргэн Харах

Эргэн ХАРАХ гэдэг нь Бурханы итгэмжит чанарыг болон нэг нэгнийхээ өсөлтийг магтан сайшааж халамжилдаг бүлгийг бий болгохыг хэлнэ.

Халамж

Амьдралаа хуваалцах (эрүүл мэнд, гэр бүл, санхүү, сүнслэг хэрэгцээ зэргээ хуваалцдаг) мөн нэг нэгнийхээ төлөө залбирах.



Магтаал

Бурханыг магтан дуу, хөгжим, бүжиг эсвэл гэрчлэлээр магтан алдаршуулах.



Алсын Хараа

Хэрхэн Есүсийн сайн дагалдагч болох болон бусдад Есүсийг таниулахын тулд бүлэг юу хийх талаар хуваалцана.



Хариуцлагатай

Үгэнд дуулгаварлах болон дагалдуулах үүргээ хэрхэн хийж байгаагаа хуваалцана.



Дээш Харах

ДЭЭШ харах гэдэг нь хамтдаа Бурханыг сонсох гэсэн утгатай. Гар утас эсвэл таблетаараа Есүс Киноны дараагийн хэсгийг үзэж, хамтаа ярилцаарай.

АЛХМУУД



1

Үзүүлэх: Хэсгийг хоёр удаа үзэх



2

Хэлэх: Бүлгийн аль нэг хүнээр тухайн түүхийг өөрийнх нь үгээр яриулна.



3

Гүйцээх: Тэрээр түүхийг өгүүлэхдээ орхигдуулсан зүйл байвал бүлгийн гишүүд нөхөж гүйцээж ярина.



4

Хэлэлцүүлэг:

- Түүхийн аль хэсэг өөрт чинь таалагдсан бэ?
- Энэ хэсгээс бид Бурханы тухай сурч болох вэ?
- Энэ хэсгээс хүн төрөлхтний тухай юу сурч болох вэ?
- Энд дуулгавартай дагах ёстой зарчим эсвэл тушаал байна уу?
- Энд зайлсхийх ёстой гэм нүгэл байна уу?
- Энд дуурайх үлгэр жишээ байна уу?



Урагш Харах

УРАГШ харах гэдэг нь хичээлийг хэрэгжүүлж, түүхийг дадлагажуулж, хамтдаа залбирснаар илгээлтийн хараатай бүлгийг бэлтгэхийг хэлнэ.

Хэрэгжүүлэх

- Бурхан биднийг өнөөдөр сурсан зүйлээ яаж хэрэгжүүлээсэй гэж хүсэж байгаа талаар хуваалцах.
- Энэ түүхийг сонсох хэрэгтэй хүн танай эргэн тойронд байгаа эсэхийг бодох.



Дадлагажуулах

- Нэг нэгэндээ түүхийг ярих.



Урих

- Өнөөдрийн түүхийг бусдад ярьж, дараагийн уулзалтад урих.



Залбирах

- Сурсан зүйлийнхээ төлөө Бурханд талархах.
- Бүлгийн бусад хүмүүсийн төлөө залбирах.
- Бүлэг нэг нэгнийхээ төлөө залбирах.

